



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/211

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.1.10, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 18 дугаар зүйлийн 18.2.4, Ус сувгийн удирдах газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.13 заалт, Хамтын гэрээний 5 дугаар зүйлийн 5.8 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын байранд ажилчдын эрүүл мэндэд тогтмол хяналт тавих, мэргэжлээс шалтгаалах өвчний тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Эмчийн үзлэгт хамруулах” журмыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмаар хэрэгжүүлэн ажиллахыг зохион байгуулалтын нэгжүүдийн удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженерүүд, эмч нарт даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Үйл ажиллагааны хяналтын хэлтэс /У.Лхамсүрэн/, Хангамж үйлчилгээний хэлтэс /Ж.Насантогтох/, Эдийн засаг бүртгэлийн хэлтэс /Ч.Ариунаа/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан газрын даргын 2007 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/116 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.ТӨРХҮҮ

Ус сувгийн удирдах газрын даргын
2018 оны 02 дугаар сарын 27-ны/ний/
өдрийн 121 тоот тушаалын хавсралт

ЭМЧИЙН ҮЗЛЭГТ ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг: Зорилго

Энэхүү журмыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Ус сувгийн удирдах газрын дүрэм, журам, Хамтын гэрээнд нийцүүлэн зохион байгуулалтын нэгжүүдийн ажлын байранд ажилтнуудын эрүүл мэндэд тогтмол хяналт тавих, мэргэжлээс шалтгаалах өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, ажлын байранд үүсэж болзошгүй осол, гэмтлээс урьдчилан сэргийлэхэд гол зорилго оршино.

Хоёр: Үзлэгийн төрөл

2.1 Үзлэг дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн хугацаат үзлэг
2. Урьдчилан сэргийлэх үзлэг
3. Өдөр тутмын үзлэг

2.2 Эрүүл мэндийн хугацаат үзлэг

1. Байгууллага жил бүр хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөнд хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилдаг ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах зардлыг тусган эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тухайн ажилтнуудыг бүрэн хамруулж, мэргэжлийн тохироог тодорхойлуулж, дүгнэлт гаргуулах.

2.2.1 Явагдах зарчим

1. Байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хороо болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилдаг ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгийг зохион байгуулах эмнэлгийг сонгох.
2. Тухайн сонгогдсон эмнэлэгтэй эрүүл мэндийн хугацаат үзлэг явуулах гэрээ байгуулах.
3. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт бүрэн хамруулан ажиллахыг Зохион байгуулалтын нэгжүүдийн удирдлага, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн инженер, эмч нар хариуцан ажиллах.

2.3 Урьдчилан сэргийлэх үзлэг

1. Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилд шинээр орж буй ажилтан харьяа дүүргийн Эрүүл мэндийн төвд, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдан, эрүүл мэндийн хуудсыг байгууллагын эмчид хянуулах.
2. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилд шинээр орж байгаа ажилтан Мэргэжлийн өвчин судлалын газрын эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдан, эрүүл мэндийн хуудсыг байгууллагын эмчид хянуулах.
3. Ус түгээх байрны ус түгээгч нар жилд хоёр удаа харьяа дүүргийн Эрүүл мэндийн төвд, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд бүрэн хамрагдан, эрүүл мэндийн дэвтрийг байгууллагын эмчид хянуулах.

2.5 Өдөр тутмын үзлэг

1. Ажлын байранд хийгдэх өдөр тутмын үзлэг, хяналт нь Зохион байгуулалтын нэгжүүдийн эмч нарын үзлэгийн өрөө болон цэг салбарын ажлын байранд явагдах.
2. Хөдөлмөрийн хэвийн бус болон хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад өдөр тутмын эрүүл мэндийн үзлэг, эмчилгээг хуваарийн дагуу эмч нар гардан хийх.

Гурав: Явагдах зарчим, хамрах хүрээ

- 3.1. Байгууллагын автомашин, механизмын жолооч, засварчид өглөө ажилд гарахын өмнө эмчийн батлагдсан графикайн дагуу өдөр тутмын эрүүл мэндийн үзлэгт биечлэн орж, тухайн өдрийн замын хуудсан дээр эмчийн тэмдэглэл хийлгүүлсэн байх.
- 3.2. Эмчийн үзлэгээр биеийн байдал зовиуртай хурц болон архаг өвчний сэдрэлт тод илэрсэн ажилтны тухай удирдлага болон хариуцсан инженер техникийн ажилтан, механикт танилцуулан анхны тусламж үзүүлэн, ажилтанг тухайн өдөр өвчний учир ажлаас чөлөөлөн онош тодруулах үзлэг, шинжилгээ хийлгэх болон эмчилгээний заавар зөвлөмж өгөх.
- 3.3. Ажлын байрны өдөр тутмын эрүүл мэндийн хяналтын үзлэгт орсон ажилтнууд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн инженер болон хариуцсан инженер техникийн ажилтан, механикаас ажил үүрэгтэй холбогдуулан аюулгүй байдлын

заавар, зааварчилгаа авч дэвтэрт гарын үсэг зурж ажилд гарах.

3.4. Ус түгээгч нар эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдан эмчийн бичилт хийлгэсэн эрүүл мэндийн дэвтрээ үргэлж биедээ авч явахыг анхаарах.

Дөрөв: Үзлэг явагдах хугацаа

4.1 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилдаг ажилтнууд тухайн жилийн эрүүл мэндийн хугацаат үзлэгийн батлагдсан графикийн дагуу бүрэн хамрагдах.

4.2 Цэвэрлэх байгууламжийн алба, Автобааз, Үйлчилгээний хэсгийн эмч нарын ажлын байранд явагдах өдөр тутмын эрүүл мэндийн хяналтын үзлэг ажлын өдөр бүр өглөөний 07⁰⁰ - 10³⁰ -ийн хооронд явагдах.

4.3 Бусад зохион байгуулалтын нэгжүүдийн ажилтнуудад өдөр тутмын эрүүл мэндийн хяналтын үзлэг, эмчилгээ батлагдсан графикийн дагуу цэг салбарын ажлын байруудад явагдах.

Тав: Тайлан

5.1 Зохион байгуулалтын нэгжийн эмч нар эрүүл мэндийн хугацаат үзлэгийн дүгнэлтийг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн хуралд танилцуулах.

5.2 Эрүүл мэндийн хугацаат үзлэгээр тухайн ажлын байрны нөхцөлийг өөрчлөх дүгнэлт гарсан ажилтны талаар мэдээлэл өвчний түүх, ажлын байрны нөхцөл өөрчлөх болсон шалтгааныг зохион байгуулалтын нэгжийн ИТА хурлаар хэлэлцэн албан бичгээр Захиргаа удирдлагын хэлтэст хандаж шийдвэр гаргуулах.

5.3 Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ажилтнуудын хөдөлмөрийн чадвар түр алдсаныг тодорхойлсон акт, листэнд хяналт тавьж, өвчлөлтийн шалтгааныг тодруулан удирдлагадаа сар бүр тайлагнаж байх.

Зургаа: Хариуцлага

6.1 Байгууллагын хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилдаг ажилтнууд эрүүл мэндийн үзлэгт хуваарь, графикийн дагуу хүндэтгэх шалтгаангүй улмаас хамрагдаагүй ажилтанг тухайн өдрийн ажил тасалсанд тооцох.

6.2 Зохион байгуулалтын нэгжийн удирдлага, ХАБЭА-н инженер, эмч нар эмнэлгийн төлөвлөгөөт үзлэгийг хугацаанд нь зохион байгуулаагүй, ажилтнуудаа

бүрэн хамруулаагүй бол холбогдох дүрэм журмын дагуу хариуцлага хүлээлгэх.

6.3 Ажлын байранд хийгдэх эрүүл мэндийн өдөр тутмын хяналтын үзлэгт автомашин, механизмын жолооч, засварчид хүндэтгэх шалтгаангүйгээр ороогүй тохиолдолд холбогдох инженер техникийн ажилтнууд тухайн ажилтныг ямар шалтгаантай байсныг тогтоож доорх арга хэмжээг авах. Үүнд:

6.3.1 Анхааруулах

6.3.2 Сарын ажиллагааны үр дүнгийн шагналаас 4%-ийг хасах

6.3.3 Тухайн өдөр ажилд гаргахгүйгээр ажил тасалсанд тооцож цалинг хасах